



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2020 оны 12 сарын 28 өдөр

Дугаар 729

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө худалдан авах,  
үнийн дээд хязгаарыг тогтоох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 3.3, 3.4 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Гаалийн ерөнхий газар, түүний харьяа газрын өндөржүүлсэн бэлэн байдалд шилжин ажиллаж байгаа албан хаагчдыг зөөвөрлөх албан хэрэгцээнд зориулан 2020 оны тодотгосон урсгал төсвөөс 1,515,100,000.00 (нэг тэрбум таван зуун арван таван сая) төгрөгт багтаан үндсэн хөрөнгө худалдан авахыг зөвшөөрч, үнийн дээд хязгаарыг хавсралтаар тогтоосугай.

2. Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Наранцогт, Гаалийн ерөнхий газрын дарга Б.Асралт нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгө худалдан авах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

*D. Narangerel*

Д.НАРАНГЭРЭЛ

13201653

Төрийн өмчийн бодлого,  
зохицуулалтын газрын 2020  
оны 12 дугаар сарын 28-ний  
өдрийн 729 дүгээр тогтоолын  
хавсралт

**Гаалийн ерөнхий газар, түүний харьяа байгууллагуудад  
худалдаж авах хөрөнгийн үнийн дээд хязгаар**

Д/д	Хөрөнгийн нэр	тоо ширхэг	Нийт үнэ (төгрөгөөр)
1	Гаалийн ерөнхий газар болон харьяа Гаалийн салбарт худалдан авах суудлын автомашин /жижиг/	2	180,000,000.00
2	гаалийн газар, хороодод яаралтай дуудлага үйлчилгээнд туулах чадвар сайтай тээврийн хэрэгсэл худалдан авах	8	1,335,100,000.00
	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>10 (арав)</b>	<b>1,515,100,000.00 (нэг тэрбум таван зуун арван таван сая )</b>